


### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

БАТЛАВ  
БООМТЫН СЭРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ  
ХОРООНЫ АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА  О.НАРАНДЭЛГЭР

2024.11.14

УТ40407  
002090905 6918073

### МОНГОЛ УЛСЫН БООМТЫН ХӨГЖЛИЙН ОРОН ЗАЙ ТӨЛӨВЛӨЛТ, ГАЗАРЗҮЙН БАЙРШЛЫН МЭДЭЭЛЛИЙН САНГ ҮҮСГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

202...оны ... дугаар сарын ... өдөр

Улаанбаатар хот

1	Үйлчилгээний нэр	Монгол Улсын боомтын хөгжлийн орон зай төлөвлөлт, газарзүйн байршлын мэдээллийн санг бүрдүүлэх судалгаа
2	Захиалагч	Боомтын сэргэлтийн Үндэсний хороо
3	Зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх хугацаа	Нийт хугацаа: гэрээ байгуулсан өдрөөс эхлэн 30 хоногийн дотор Эхлэх: 2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр Дуусгах: 2024 оны ... дүгээр сарын ...-ны өдөр
4	Үйлчилгээний үнэлгээ /төсөв/	49,400.00 мянган төгрөг
5	Үйлчилгээний үндэслэл, хэрэгцээ шаардлага	Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын 21.4 Олон улс, бүс нутгийн эдийн засгийн интеграци болон дэд бүтцийн сүлжээнд нэгдэхийг эрмэлзэх, далайн боомт хүрэх, дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 4.2 Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно. Үүний дотор Үндэсний тээвэр, логистикийн тогтолцоог хөгжүүлсэн байна, 4.4, Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэж, худалдааг хөнгөвчилнө, 8.1, Өрнө-Дорнын бүсийн орнуудыг холбох дэд бүтцийн хөндлөн гол тэнхлэгийн авто зам болон хойд, урд хөршийг холбох зарим бүсийн босоо тэнхлэгийн авто замыг барьж худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох суурь нөхцөлийг бүрдүүлсэн байна, Шинэ сэргэлтийн бодлогын Боомтын сэргэлтийн хүрээнд 1.1.Боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлнэ, 1.2 Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ, 1.3.1 Агаарын замын байнгын ажиллагаатай олон улсын боомтын тоог нэмэгдүүлж, карго тээвэр, аялал жуулчлалыг хөгжүүлэх", "Орон нутгийн нисэх буудлын

		хүчин чадлыг сайжруулж, 6 нисэх буудлыг зорчигч, ачаа тээврийн харилцааны хилийн олон улсын боомт болгосон байна. Энэхүү шаардлагын хүрээнд Монгол Улсын боомтын хөгжлийн орон зай төлөвлөлт, газарзүйн байршлын мэдээллийн санг бүрдүүлэх судалгаа хийх шаардлага үүсээд байна.
6	<b>Судалгааны зорилго</b>	Монгол Улсын урт, дунд хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан хилийн боомтын сэргэлттэй холбоотойгоор Хилийн боомтын газарзүйн байршил, орон зайн төлөвлөлттэй холбоотой мэдээллийн сан үүсгэх.
7	<b>Үйлчилгээний хүрээнд хийгдэх ажил</b>	<p>Монгол Улсын боомтын хөгжлийн орон зай төлөвлөлт, газарзүйн байршлын мэдээллийн санг бүрдүүлэх судалгааны хүрээнд дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хилийн боомтуудын газарзүйн байршил /GIS Shapefile*/</li> <li>• Хилийн боомтуудтай холбогддог авто замын трассын зураглал /GIS Shapefile*/, зэрэглэл болон хучилтын төрлөөр</li> <li>• Хилийн боомтуудтай холбогддог төмөр замын трассын зураглал /GIS Shapefile*/</li> <li>• Хил орчмын бүс нутгийн аймаг, сумын хилийн цэсийн мэдээлэл /GIS Shapefile*/</li> <li>• Аймаг, сум, багийн төвийн байршил /GIS Shapefile*/</li> <li>• Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн газарзүйн байршил, холбогдох мэдээлэл /GIS Shapefile*/</li> <li>• Хилийн боомттой холбогдсон эрчим хүчний сүлжээний зураглал /GIS Shapefile*/</li> <li>• ОХУ-ын Сибирийн бүс нутаг, БХНАУ-ын тээврийн гол коридор, Бүс нутгийн хамтын ажиллагаа (Төв Ази, Зүүнхойд Ази), Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридортой холбоотой тээврийн дэд бүтцийн маршрут газарзүйн мэдээлэл /GIS Shapefile*/</li> </ul> <p>Зөвлөх үйлчилгээний хүрээнд дээрх мэдээллийн санг цахим хэлбэрээр, мэдээллийн сангийн агуулгыг бүхий тайланг цаасан хэлбэрээр боловсруулж өгнө.</p>
8	<b>Үйлчилгээний ажлын хүрэх үр дүн болон хэрхэн ашиглах талаар төсөөлөл</b>	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг, төсөл арга хэмжээг төлөвлөх хэрэгжүүлэхэд шаардлагатай Монгол Улсын боомтын хөгжлийн орон зай төлөвлөлт, газарзүйн байршлын мэдээллийн санг бүрдүүлэх судалгаа хийж гүйцэтгэснээр цаашид төрийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд ашиглана.
9	<b>Судалгааны тайлангийн үе шат</b>	<p><u>Эхлэлийн тайлан:</u> Гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор дараах ажлыг гүйцэтгэн захиалагч талд хүлээлгэн өгнө. - Уг тайланд ажлын даалгавар, гэрээний зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, хуваарь багтана.</p> <p><u>Эцсийн тайлан:</u> Гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор буюу 20...оны ... дугаар сарын ...-ны өдөр дараах ажлуудыг гүйцэтгэн захиалагч талд хүлээлгэн өгнө.</p>

		<p>a) Ажлын даалгаварт заасан дата, мэдээллийг цахим хэлбэрээр өгнө, /*.excel, ShP.file өргөтгөлтэй/;</p> <p>b) Мэдээллийн сангийн товъёг, агуулгыг бүхий тайланг цаасан хэлбэрээр захиалагчид өгнө /*.doc өргөтгөлтэй/;</p>
--	--	--